



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 02

Сүхбаатар сум

Салбар комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.3, 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.5, 3.5.3 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2021 оны 3 дугаар сард зохион байгуулагдах төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комисс, техникийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Шалгалтын комиссын дарга

Д.Лувсандагва -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Нарийн бичгийн дарга:

Ш.Энхмаа -Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Б.Болорзул -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Д.Ёндонжамц -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

А.Эрдэнэгэрэл -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

М.Нямсүрэн -Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Б.Саранчимэг -Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Техникийн ажлын хэсэг:


Ч.Гандүүрэн -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
мэргэжилтэн

Б.Ариундэлгэр -Мөн хэлтсийн мэргэжилтэн

С.Жавзанжамба -Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын  
хэлтсийн мэргэжилтэн

2. Ерөнхий шалгалтыг зохион байгуулах бэлтгэлийг сайтар хангаж, тайлан мэдээг холбогдох журмын дагуу Төрийн албаны Зөвлөл, ерөнхий шалгалтыг зохион байгуулах төв комисст хүргүүлж ажиллахыг салбар комиссын дарга /Д.Лувсандагва/-д даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА

Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь  
Салбар зөвлөлийн 2021 оны 08-р сарын  
23-ны өдрийн ... тоот тогтоолын хавсралт

"ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖИЛ"-ИЙН  
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналт тавих байгууллага, албан тушаалтан
	Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар			
1	Зарласан жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, сум, байгууллагуудад хүргүүлэх	2021 оны 3 дугаар сарын 1-ний дотор	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаа
2	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, танилцуулах	Жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл, бүх шатны төр, төсвийн байгууллагууд	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаа
3	Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд төрийн албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	2021 оны 4-р сарын 21-ний дотор	Статистикийн хэлтэс, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Энхмаа
4	Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	2021-2022 онд	Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар

хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтран ажиллах	салбар зөвлөл, Хэлний бодлогын салбар зөвлөл	зөвлөлийн дарга
Хоёр. Төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх талаар		
5 "Үндэсний бичиг-Үндэсний дархлага" аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, үр дүнг тооцох	Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл, Боловсрол, соёл, урлагийн газар, Төр, төсвийн байгууллагууд	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ёндонжамц
6 Төрийн албан хаагчдын дунд "Монгол бичгийн цэвэр сайхан бичигтэн", "Бийрэн бичиг"-ийн уралдааныг тус тус зохион байгуулж, дүгнэх	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Болорзул
7 Төрийн албан хаагчдын "Монгол бичиг"-ийн аймгийн олимпиадыг зохион байгуулах	Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөл, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Энхбат
8 Үндэсний бичиг соёлыг сурч мэдэх ач холбогдлын талаарх эрдэмтэн, судлаачийн уулзалтыг зохион байгуулах	Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газар	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Болорзул
9 ЕБС-ийн монгол, хэл бичгийн мэргэжлийн багш нарын дунд үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр уралдаан зарлаж, урамшуулах	Боловсрол, соёл, урлагийн газар	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Энхбат
10 Байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой заалтыг тусган, байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох хөдөлгөөнийг өрнүүлэх	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн дарга, гишүүд

11	Орон нутгийн боловсролын байгууллагын монгол, хэл бичгийн мэргэжлийн багш нартай хамтран байгууллагын төрийн албан хаагчдын монгол бичгийн түвшинг тодорхойлж, шаталсан сургалтыг зохион байгуулах	2021-2022 онд	Сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, төр, төсвийн байгууллагууд	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Болорзул
12	Байгууллага бүр "Хүмүүн бичиг" сонинг захиалж, монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, ном гарын авлагын буланг байгуулж, байгууллагын үйл ажиллагаандаа ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлэх	2021 онд	Сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, төр, төсвийн байгууллагууд	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ёндонжамц
13	Үндэсний бичгийн чиглэлээр зохион байгуулж буй уралдаан тэмцээнд албан хаагчдыг идэвхтэй оролцуулах	2021, 2022 онд	Сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, төр, төсвийн	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн дарга, гишүүд
14	Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд албан ёсны стандарт, шаардлагыг хангасан монгол бичгийн фонтыг компьютерт суулгаж, хэрэглээнд нэвтрүүлэх	2021 онд	Сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, төр, төсвийн	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн дарга, гишүүд
15	Төрийн байгууллагын хаяжилт, өрөөний хаяг, албан хаагчийн нэр, албан тушаалыг үндэсний бичгээр зэрэгцүүлэн бичиж байршуулах	2021-2022 онд	Сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, төр, төсвийн	ТАЗСЗ-ийн гишүүн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Саруултөгс
16	Аймаг, сумдын цахим хуудас, "Өргөн Сэлэнгэ" сэтгүүлд үндэсний бичгийн мэдээллийн буланг нээх	2021 онд	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод

					аудитын хэлтсийн дарга Д.Лувсандагва
17	Монгол бичгийн цуврал хичээлийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран явуулах	2021-2022 онд	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газар	ТАЗСЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Лувсандагва	
18	Байгууллагын албан бичиг хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах туршилтыг амжилттай зохион байгуулж, өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн байгууллагуудыг урамшуулах ажлыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулах	2021-2022 онд	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл	Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаа	